



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР  
НӨЛӨӨ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БНА-2022/30-ШТА-ГА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр  
Утас: 70483413

Цахим хаяг: Tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Цэцэгмаа

Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn

Аудитор Э.Сүнжидмаа

Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Аудитор Ц.Сайханжаргал

Цахим хаяг: Saikhanjargalts@audit.gov.mn

Аудитор Б.Цэвэлмаа

Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn


Аудитор С.Санчирмаа

Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn

АГУУЛГА

<b>Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:</b> .....	<b>5</b>
<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</b> .....	<b>8</b>
<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> .....	<b>8</b>
<b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ХУУЛИАР ОЛГОГДСОН ЭХ ҮҮСВЭРИЙН БОЛОМЖИЙГ АШИГЛААГҮЙ, ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН БАЙНА.</b> .....	<b>11</b>
<b>1.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН НЭР ТӨРЛӨӨР ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.</b> .....	<b>11</b>
1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн эсэхийг орон нутгийн төвшинд үзэх боломжгүй байна. ....	11
1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилж олгожээ. ....	11
1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан төсвийн дагуу олгожээ. ....	11
1.1.4. Сумдын ОНХС-д хуулиар олгогдсон эх үүсвэрийн боломжийг ашиглаагүй, хууль, журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлэхэд идэвхи санаачилга гаргаж ажиллаагүй байна. ....	12
<b>1.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨСӨН Ч ИРГЭДИЙН САНАЛ, АВААГҮЙ, ТЭЗҮ, АЖЛЫН ДААЛГАВАР, ЗУРАГ ТӨСӨВГҮЙ ТАХ-Г ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛЖЭЭ.</b> .....	<b>13</b>
1.2.1. ОНХС-ийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангаагүй, иргэдийн санал аваагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна. ....	13
1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна. ....	16
1.2.3. ОНХС-аас Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна. ....	16
1.2.4. Зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсаар байна. ....	17
<b>БҮЛЭГ 2. ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧАНАР, АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ ЗОХИСГҮЙ БАЙГАА ХЭДИЙ Ч ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЖ ЧАНАРТАЙ АЖЛУУД НЬ ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХЭЭР БАЙНА.</b>	<b>18</b>
<b>2.1. БОСГО ҮНЭЭС ДАВСАН АЖИЛД ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗАРЛААГҮЙ, ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛЖ БАЙНА.</b> .....	<b>18</b>
2.1.1. Босго үнээс давсан 8 төсөл арга хэмжээг ХАА зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн. ....	18
2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг төсвийн байгууллагын урсгал зардал, ИТХ-аар батлагдаагүй ТАХ, нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаанд зарцуулсан байна. ....	19
<b>2.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ УРТ ХУГАЦААНД ТОДОРХОЙЛОХООР БАЙНА.</b> .....	<b>19</b>
2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр өгөөжийг урт хугацаанд үнэлэхээр байна. ....	19
2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлууд нь орон нутагт иргэд ая, тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж байна. ....	20
<b>2.3. ОНХС-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ЗАРИМ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.</b> .....	<b>21</b>
2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгө ашиглалтгүй байна. ....	21
2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр 2013 оноос хойш хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна. ....	22
<b>БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНААГҮЙ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙГ ҮНЭН ЗӨВ, ИЖ БҮРЭН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГААГҮЙ БАЙНА.</b> .....	<b>23</b>
<b>3.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦАД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.</b> .....	<b>23</b>
3.1.1. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний үр дүнд тавих хяналт хэрэгжүүлээгүй байна. ....	23

3.1.2. Захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээр хөрөнгө оруулалтын ажил гэрээт хугацаанд хийгдэхгүй удааширч, төсвийн хөрөнгө үнэгүйдэж, ард иргэдийн хүртэх үр өгөөж буурч байна.....	23
3.1.3. Журамд заасан дотоод хяналт шалгалтыг хийхгүйгээс зөрчил жил бүр давтагдан гарсаар байна.....	25
3.2. ОНХС-ийн ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ЗААВАР ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАЖ ХҮРГҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.....	27
3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнаагүй.....	27
3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон зарим хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байна.....	27
3.2.3. Удирдлагын мэдээллийн системд сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар иж бүрэн мэдээллийг оруулаагүйгээс иргэд, олон нийт үнэн зөв мэдээллээр хангагдахааргүй байна.....	28
3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцорч мэдээлсэн байна.....	28
<b>ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЕ ШАТ БҮРД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ, ЖУРАМД ЗААСАН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН ДЭЭШЛЭХЭЭР БАЙНА.....</b>	<b>29</b>
<b>ЗӨВЛӨМЖ: 29</b>	
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГАД:.....	29
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:.....	29
АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ:.....	29
АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСТ:.....	30
Холбогдох байгууллагын санал:.....	36



## Товчилсон үгийн тайлбар

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАА	Говь-Алтай аймаг
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс



### Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Орон нутгийн хөгжлийн сангаас аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ /сая.төг/	10
Хүснэгт №2	Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/	12
Хүснэгт №3	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ /сая.төг/	18
Хүснэгт №4	Олон давтамжтай хэрэгжсэн ТАХ	19
Хүснэгт №5	ТА-3 төслийн 2021 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээ	25

### Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоо	13
Дүрслэл №2	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын санал авсан, эрэмбэлсэн байдал /сая.төг/	14
Дүрслэл №3	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан ажлын төлөвлөлтийн шаардлага хангасан байдал /сая.төг/	16

### Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг №1	ОНХС-ийн цикл	8
Зураг №2	Алтай хотын шинэ суурьшлын бүс	20
Зураг №3	“Суурин дулаан” ААТҮГ	20
Зураг №4	Хог тээврийн автомашин	21
Зураг №5	Хогийн бункер, хог тээврийн автомашин	21
Зураг №6	Хөл бөмбөгийн талбай	21
Зураг №7	Шүтээний өндөрлөг цогцолборын их засвар	21
Зураг №8	Төв стадионы засвар	21
Зураг №9	Явган хүний зам	21
Зураг №10	Эрдэнэ сумын Спорт заал	24
Зураг №11	Алтай сумын Спорт заал	24

### Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл	11
Хавсралт №2	Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны төлөвлөлтөд иргэдийн оролцоо	13
Хавсралт №3	Алслагдсан багийн саналыг дэмжиж хэрэгжүүлсэн ТАХ-ны судалгаа	14
Хавсралт №4	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын санал авсан, эрэмбэлсэн байдал	16
Хавсралт №5	ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй ажлыг төлөвлөсөн эсэх	17
Хавсралт №6	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өмнөх онуудад хийгдсэн ажлуудаас хүлээж авсан баримтгүй ажлын жагсаалт	24
Хавсралт №7	Өмнөх оны ОНХС-ийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	25



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 111.

Алтай хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.

  
Х.ТҮВШИНБАЯР

0 000034

Говь-Алтай аймаг дахь Төрийн  
аудитын газрын дарга, тэргүүлэх  
аудиторын  
2022 оны 06 дугаар сарын 03-ны  
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

ДД	Хариуцагч	Товч утга	Дугаар	Зөрчлийн дүн	Аудитын нэр
1	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгах тухай	01/198	154.9	*Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө* гүйцэтгэлийн аудит
2	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгах тухай	02/198	1,400.9	
3	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгах тухай	03/198	1,356.3	
4	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгах тухай	04/198	0	
5	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгах тухай	05/198	0	
6	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгах тухай	06/198	0	
7	Алтай сум	Зөрчил арилгах тухай	07/198	0	
8	Алтай сум	Төлбөр барагдуулах тухай	01/117	0.3	
9	Алтай сум	Зөрчил арилгах тухай	08/198	4.6	
10	Алтай сум	Зөрчил арилгах тухай	09/198	4.6	
11	Алтай сум	Зөрчил арилгах тухай	10/198	41.3	
12	Алтай сум	Зөрчил арилгах тухай	11/198	0	
13	Бигэр сум	Зөрчил арилгах тухай	12/198	0	
14	Бигэр сум	Зөрчил арилгах тухай	13/198	12.6	
15	Баян-уул сум	Зөрчил арилгах тухай	14/198	3.4	
16	Баян-уул сум	Зөрчил арилгах тухай	15/198	1.4	
17	Баян-уул сум	Зөрчил арилгах тухай	16/198	6.4	
18	Бугат сум	Зөрчил арилгах тухай	17/198	0	
19	Бугат сум	Зөрчил арилгах тухай	18/198	0	
20	Бугат сум	Зөрчил арилгах тухай	19/198	5.0	
21	Дарив сум	Зөрчил арилгах тухай	20/198	0	
22	Дарив сум	Зөрчил арилгах тухай	21/198	0	
23	Дарив сум	Зөрчил арилгах тухай	22/198	0	
24	Дарив сум	Зөрчил арилгах тухай	23/198	10.0	
25	Дарив сум	Зөрчил арилгах тухай	24/198	14.2	
26	Дарив сум	Зөрчил арилгах тухай	25/198	5.0	
27	Дарив сум	Зөрчил арилгах тухай	26/198	30.6	
28	Дэлгэр сум	Зөрчил арилгах тухай	27/198	0	
29	Дэлгэр сум	Зөрчил арилгах тухай	28/198	0	
30	Дэлгэр сум	Зөрчил арилгах тухай	29/198	120.7	
31	Дэлгэр сум	Зөрчил арилгах тухай	30/198	67.4	
32	Дэлгэр сум	Зөрчил арилгах тухай	31/198	65.0	
33	Дэлгэр сум	Зөрчил арилгах тухай	32/198	6.5	
34	Жаргалан сум	Зөрчил арилгах тухай	33/198	0	
35	Дэлгэр сум	Төлбөр барагдуулах тухай	02/117	0.6	
36	Жаргалан сум	Зөрчил арилгах тухай	34/198	0	
37	Жаргалан сум	Зөрчил арилгах тухай	35/198	77.3	
38	Жаргалан сум	Зөрчил арилгах тухай	36/198	8.5	
39	Жаргалан сум	Зөрчил арилгах тухай	37/198	0	

40	Жаргалан сум	Зөрчил арилгах тухай	38/198	10.0	“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудит	
41	Тайшир сум	Зөрчил арилгах тухай	39/198	17.6		
42	Жаргалан сум	Төлбөр барагдуулах тухай	03/117	18.9		
43	Тайшир сум	Зөрчил арилгах тухай	40/198	0		
44	Тайшир сум	Зөрчил арилгах тухай	41/198	0		
45	Тайшир сум	Зөрчил арилгах тухай	42/198	40.4		
46	Тайшир сум	Зөрчил арилгах тухай	43/198	138.8		
47	Тонхил сум	Зөрчил арилгах тухай	44/198	0		
48	Тонхил сум	Төлбөр барагдуулах тухай	04/117	71.2		
49	Тонхил сум	Зөрчил арилгах тухай	45/198	0		
50	Тонхил сум	Зөрчил арилгах тухай	46/198	59.1		
51	Төгрөг сум	Зөрчил арилгах тухай	47/198	0		
52	Төгрөг сум	Зөрчил арилгах тухай	48/198	2.0		
53	Халиун сум	Зөрчил арилгах тухай	49/198	0		
54	Халиун сум	Зөрчил арилгах тухай	50/198	0		
55	Халиун сум	Зөрчил арилгах тухай	51/198	75.5		
56	Халиун сум	Зөрчил арилгах тухай	52/198	14.0		
57	Халиун сум	Зөрчил арилгах тухай	53/198	0.8		
58	Халиун сум	Зөрчил арилгах тухай	54/198	0		
59	Хөхморьт сум	Зөрчил арилгах тухай	55/198	0		
60	Хөхморьт сум	Зөрчил арилгах тухай	56/198	23.5		
61	Хөхморьт сум	Зөрчил арилгах тухай	57/198	0		
62	Хөхморьт сум	Зөрчил арилгах тухай	58/198	20.0		
63	Хөхморьт сум	Зөрчил арилгах тухай	59/198	0.6		
64	Хөхморьт сум	Зөрчил арилгах тухай	60/198	51.7		
65	Цогт сум	Зөрчил арилгах тухай	61/198	0		
66	Цогт сум	Зөрчил арилгах тухай	62/198	3.6		
67	Цогт сум	Зөрчил арилгах тухай	63/198	168.1		
68	Цээл сум	Зөрчил арилгах тухай	64/198	70.0		
69	Цээл сум	Зөрчил арилгах тухай	65/198	9.8		
70	Цээл сум	Зөрчил арилгах тухай	66/198	0		
71	Чандмань сум	Зөрчил арилгах тухай	67/198	0		
72	Чандмань сум	Зөрчил арилгах тухай	68/198	0		
73	Чандмань сум	Зөрчил арилгах тухай	69/198	2.0		
74	Шарга сум	Зөрчил арилгах тухай	70/198	0		
75	Шарга сум	Зөрчил арилгах тухай	71/198	5.9		
76	Шарга сум	Зөрчил арилгах тухай	72/198	52.5		
77	Шарга сум	Зөрчил арилгах тухай	73/198	0.8		
78	Эрдэнэ сум	Зөрчил арилгах тухай	74/198	0		
79	Эрдэнэ сум	Төлбөр барагдуулах тухай	05/117	1.4		
80	Эрдэнэ сум	Зөрчил арилгах тухай	75/198	0		
81	Эрдэнэ сум	Зөрчил арилгах тухай	76/198	32.4		
82	Эрдэнэ сум	Зөрчил арилгах тухай	77/198	0		
83	Есөнбулаг сум	Зөрчил арилгах тухай	78/198	0		
84	Есөнбулаг сум	Төлбөр барагдуулах тухай	06/117	0.3		
85	Есөнбулаг сум	Зөрчил арилгах тухай	79/198	103.8		
86	Есөнбулаг сум	Зөрчил арилгах тухай	80/198	4.5		
87	Есөнбулаг сум	Зөрчил арилгах тухай	81/198	5.0		
88	Есөнбулаг сум	Зөрчил арилгах тухай	82/198	327.3		
89	Дарив сум	Зөрчил арилгах тухай	83/198	0		
	<b>Нийт дүн</b>			<b>4,729.0</b>		

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу хийлээ.

**Аудитын зорилт**

“Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитад ОНХС-ийн 2021 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, багийн ИНХ, аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн холбогдох үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817:2020 3 Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” MNS 6817:2020 3 Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр хянан удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж стандартыг хангуулан, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор Э.Сүнжидмаа, Ц.Сайханжаргал, Б.Цэвэлмаа, С.Санчирмаа нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2022 оны 5 дугаар сарын 23-наас 2022 оны 5 дугаар сарын 30-нд хийж аудитын тайланг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

**Хүндрэл бэрхшээл**

Холбогдох нэгж, сумдын мэргэжилтэн, нягтлан бодогч солигдсоноос аудитад шаардлагатай баримт материал гаргаж өгөх ажил удаашралтай, лавлагаа, тодруулга авахад хүндрэлтэй байсан.

**ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

Говь-Алтай аймаг нь 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, засаг захиргааны нэгжийн хувьд 18 сум, 88 багтай 16,075 өрхөд 57,479 хүн ам амьдардаг, улсын нийслэл Улаанбаатар хотоос 1037 км алслагдсан. /Эх сурвалж: Хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллого/

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-т “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хөтөлбөрийн “Бүс орон нутгийн хөгжил” бүлэгт үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлэхээр зорилт дэвшүүлсэн байна.

Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай” 230 дугаар тогтоол гарснаар Засгийн газрын 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ийг хүчингүй болгосон. *Зураг 1. ОНХС-ийн цикл*

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж байсан бөгөөд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталжээ.

Орон нутгийн хөгжлийн сан нь Засгийн газраас орон нутгийг хөгжүүлэх зорилгоор өгч буй шилжүүлэг бөгөөд гол онцлог нь иргэдтэй хамтран орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилготой. ОНХС нь иргэдийн оролцоотой төлөвлөлт, төслийн үнэлгээ эрэмбэлэлт, хэрэгжилт болон худалдан авах ажиллагаа, хяналт-шинжилгээ үнэлгээ, хөрөнгийн удирдлага гэсэн үндсэн 5 үе шатыг хамран зохион байгуулагддаг. /Эх сурвалж: ОНХС-ийн гарын авлага/




Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Говь-Алтай аймагт нийт 10,079.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Олон Улсын Хөгжлийн Ассоциаци болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2015 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Тогтвортой амьжиргаа 3” төслийг хэрэгжүүлэхээр Зээл №5487-MN тоот санхүүжилтийн хэлэлцээр хийсэн бөгөөд тус төсөл нь хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 4 дүгээр хавсралтаар Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр буюу дээрх төслөөс 2021 онд Говь-Алтай аймагт 111.2 сая төгрөгийн дэмжлэг, 248.3 сая төгрөгийн урамшуулал буюу нийт 359.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.

ОНХС-ийн 2021 оны эх үүсвэрээр 12,932.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 279 ТАХ-г хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталснаас 10,698.7 сая төгрөгийн 214 ажлыг хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн мэдээллийг иргэдэд үнэн зөв, түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг “Тогтвортой амьжиргаа 3” төслөөс санхүүжүүлэн Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан “Удирдлагын мэдээллийн систем”-д оруулахаар заажээ.



## **БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ХУУЛИАР ОЛГОГДСОН ЭХ ҮҮСВЭРИЙН БОЛОМЖИЙГ АШИГЛААГҮЙ, ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН БАЙНА.**

1.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН НЭР ТӨРЛӨӨР ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1.1. ОНХНС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн эсэхийг орон нутгийн төвшинд үзэх боломжгүй байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1<sup>1</sup> дэх хэсэг болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.1-д заасан 4 эх үүсвэрийн хүрээнд нийт 228,260.8 сая төгрөгөөр төлөвлөж Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан байна.

Орон нутгийн хэмжээнд ОНХНС-ийн бүрдүүлэлтийг үзээгүй.

1.1.2. ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилж олгожээ.

ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2<sup>2</sup>, 59.3<sup>3</sup> дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо, нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ зэрэг шалгуур үзүүлэлтийг тус тус үндэслэн тооцоолдог.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХНС болон улсын төсвөөс Говь-Алтай аймагт нийт 10,079.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдаж, гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн олгосон.

1.1.3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан төсвийн дагуу олгожээ.

Аймгийн ОНХС-д ОНХНС-аас хуваарилсан орлогын шилжүүлгийг ажлын 3 хоногийн дотор сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарийн дагуу хуваарилахаар байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай” 18 дугаар тогтоолд сумдын ОНХС-д 3,638.7 сая төгрөг, аймгийн ОНХС-д 7,541.7 сая төгрөг нийт 11,179.4 сая төгрөгөөр орлогын шилжүүлгийг баталжээ.

*Хүснэгт 1. Орон нутгийн хөгжлийн сангаас аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ /сая.төг/*

№	Эх үүсвэр	Аймаг	Сум	Нийт дүн
1	Итгэлцүүрээр хуваарилагдсан нийт дүн	3,223.7	1,381.7	4,605.4
2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	510.0	510.1	1,020.1
3	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр	251.7	251.6	503.3
4	АМНАТ	2,084.8	1,026.9	3,111.7
5	ТА-3 төслийн урамшуулал	-	248.3	248.3
6	ТА-3 төслийн дэмжлэг	-	111.2	111.2
7	Урсгал зардал	370.5	108.9	479.4

<sup>1</sup> 59.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь;

59.1.3. орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;

59.1.5 газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

<sup>2</sup> 59.2. Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

<sup>3</sup> 59.3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

8	Урьд оны үлдэгдэл	1,100.0	-	1,100.0
	<b>Дүн</b>	<b>7,540.7</b>	<b>3,638.7</b>	<b>11,179.4</b>

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2021 оны 18 дугаар тогтоол

Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал батлах тухай”, Сангийн сайдын 2012 оны “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу аймгийн орон нутгийн төсвийг төлөвлөж баталсан байна.

1.1.4. Сумдын ОНХС-д хуулиар олгогдсон эх үүсвэрийн боломжийг ашиглаагүй, хууль, журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлэхэд идэвхи санаачилга гаргаж ажиллаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2<sup>4</sup>-т болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2-т заасны дагуу ОНХС-ийн эх үүсвэрийг 5 төрлийн орлогоос бүрдүүлэхээр байна. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС болон улсын төсвөөс 10,079.4 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 162.5 сая төгрөгийн, шилжих үлдэгдлээс 2,586.1 сая төгрөгийн нийт 12,828.0 сая төгрөгөөр баталжээ. /Хавсралт№01/

Гүйцэтгэлээр ОНХНС болон улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн олгосон, туслах үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 290.0 сая буюу төлөвлөгөөнөөс 127.5 сая төгрөгөөр давж биелсэн байна. Төлөвлөгөө давсан 127.5 сая төгрөгийн 59.8 сая төгрөг нь малын тоо толгойн албан татварын, 32.1 сая төгрөг нь дотоодын хандив тусламжийн орлого, үлдсэн 35.6 сая төгрөг нь өвс тэжээл, мал, төлбөрийн актын орлого байна.

Сумдад 2014 оноос хойш ОНХС-ийн хөрөнгө, гамшгийн сан, хандив тусламжийн эх үүсвэрээр өвс тэжээл бэлтгэн малчдад зээлээр болон бэлэн мөнгөөр борлуулах, төвлөрсөн орлогоос дахин өвс тэжээл бэлтгэх зарчмаар өвс тэжээлийн нөөц үүсгэсэн боловч энэхүү эх үүсвэрээс төвлөрвөл зохих орлогыг бүрэн төлөвлөөгүй байна.

Бараа материал данс 199.1 сая төгрөгийн өвс, тэжээлийн нөөцийн эхний үлдэгдэлтэй, тайлант онд 122.7 сая төгрөгийн өвс тэжээл бэлтгэн, 134.2 сая төгрөгийн борлуулалт хийж 3.4 сая төгрөгийн өвс тэжээлийг холбогдох шийдвэрийн дагуу акталснаар тайлант оны эцэст 184.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлага дансны эхний үлдэгдэл 310.2 сая төгрөгөөс оны эцэст 297.0 сая төгрөг болж 13.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Өвс тэжээлийг нөөцлөх нь гамшгийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж байгаа хэдий ч агуулахад өнжсөн өвсний чанар муудах, тэжээлийн хугацаа дуусах, улмаар сангийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг дагуулж байна. Тайлант онд Хөхморьт сум нь ОНХС-ийн дансанд бүртгэлтэй он өнжсөн өвс, тэжээлийг хямдруулж зарснаар 3.4 сая төгрөгийн бараа материалын гарз хүлээжээ. Цаашид ОНХС-ийн дансанд бүртгэлтэй өвс тэжээлийн авлагыг барагдуулснаар сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр байна.

<sup>4</sup> 60.2. Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

60.2.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;

60.2.4. татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

60.2.5. тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

60.2.7. ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.

60.2.8. малын тоо толгойн албан татварын орлого.

Хүснэгт 2. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ОНХС-д төвлөрүүлсэн
1	Алтай сум		0.3	
2	Дарив сум		41.6	41.6
3	Есөнбулаг		19.2	
4	Жаргалан		18.9	
5	Тонхил		71.2	
6	Хөхморьт		18.2	18.2
	Дүн		169.4	59.8

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлэх талаар санаачилга гаргаагүй, хангалтгүй ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Засгийн газрын 2012 оны 244 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1-дэх хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Эх сурвалж: СТА-ын ажлын баримт

Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр байсан боловч тус орлогыг төлөвлөөгүй байна. Малын тоо толгойн албан татварын албан татварын хэмжээг энэ хуулийн заасан хязгаарт багтаан сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтоохоор хуульчилсан. Аймгийн хэмжээнд гүйцэтгэлээр хүснэгт дэх 6 сум нийт 169.4 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлсэн боловч Дарив, Хөхморьт сумаас бусад 4 сум ОНХС-ийн эх үүсвэрт баталж, хуваарилаагүй, орон нутгийн ерөнхий орлогын дансанд байна. Есөнбулаг сум аудитын явцад ОНХС-ийн дансанд төвлөрүүлж залруулсан.

Аудитаар [www.1212.mn](http://www.1212.mn) статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас авсан аймгийн 2020 оны жилийн эцсээрх малын тоо толгойн дүнд үндэслэн албан татварын хэмжээг “Малын тоо толгойн албан татварын тухай хууль”-ийн 6.1-<sup>5</sup> дэх хэсэгт заасан хязгаарт багтаан тооцоход сумд нь 2021 онд ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг 741.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг алджээ.

**Илрүүлэлт:**

- ✓ Алтай сум 0.3 сая төгрөгийн, Жаргалан сум 18.9 сая төгрөгийн, Тонхил сум 71.2 сая төгрөгийн буюу нийт 90.4 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварын орлогыг ОНХС-д төвлөрүүлээгүй.
- ✓ Дэлгэр сумын ОНХС: Өвс тэжээлийн 6.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэл эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоогүй.
- ✓ Эрдэнэ сумын ОНХС: Иргэдэд 7.4 сая төгрөгийн 1323 боодол өвс зарсан боловч 1.3 сая төгрөгийн дутагдсан, авлагаар тусгаагүй.
- ✓ Есөнбулаг сумын ОНХС: Санхүүгийн тайлангаарх өвс тэжээлийн үлдэгдэл нярвын тайлангаас зөрүүтэй, санхүүгийн тайланд авлага 4.5 сая төгрөгөөр нэмэгдсэнийг нотлох баримтгүй байна.

**1.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨСӨН Ч ИРГЭДИЙН САНАЛ, АВААГҮЙ, ТЭЗҮ, АЖЛЫН ДААЛГАВАР, ЗУРАГ ТӨСӨВГҮЙ ТАХ-Г ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛЖЭЭ.**

1.2.1. ОНХС-ийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангаагүй, иргэдийн санал аваагүй ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Иргэдийн оролцоо нь нэг орон нутагт оршин суугаа амьдралын ижил сонирхол, хэрэгцээ бүхий хүмүүс өөрсдийн хэрэгцээгээ тодорхойлон шийдвэрлэхийн тулд нэгдэн хамтарч ажиллах үйл ажиллагаа болж байна. Иргэдийг оролцуулах нь гэнэтийн, тохиолдлын үйл явдал бус харин зохион байгуулалттай тасралтгүй үйл ажиллагаа юм.<sup>6</sup>

<sup>5</sup> 6.1. Нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байна.

<sup>6</sup> ОНХС-ийн үйл ажиллагааны гарын авлага 2019

Аймаг, сумдын Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөхөд Төсвийн тухай хуулийн 63<sup>7</sup> дугаар зүйлийн 63.1<sup>8</sup>, 63.2<sup>9</sup>, 63.3<sup>10</sup>, 63.4<sup>11</sup> дэх хэсэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12 дугаар зүйлийг мөрдлөг болгохоор байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хүчин төгөлдөр байсан цагалбарт хугацаанд 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг авсан.

Тус журмын 5 дугаар бүлэгт багийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар багийн иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг санал асуулгын хуудас, нээлттэй хэлэлцүүлэг, бүлгийн ярилцлага, цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрээр зохион явуулахаар байна.

Аудитаар 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авсан байдлыг тулган баталгаажуулахад *Дүрслэл.1 ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоо*

сонгуулийн насны 37,524 иргэний 37 хувь буюу 14,041 иргэнээс санал авсан байна. Санал авсан хэлбэрээр нь ангилбал 570 иргэнээс бүлгийн ярилцлагаар, 13,471 иргэнээс санал асуулгын хуудсаар авчээ. /Хавсралт №02/ Сумдын санал авсан байдлын багаар нь авч үзвэл Есөнбулаг сумын Оргил багийн сонгуулийн насны 1,561 иргэний 5 хувь буюу 83 иргэнээс, Дарив сумын Хужирт



Эх сурвалж: Аудитын ажлын баримт

багийн сонгуулийн насны 269 иргэний 6 хувь буюу 15 иргэнээс, Дэлгэр сумын Баянхонгор багийн сонгуулийн насны 265 иргэний 8 хувь буюу 20 иргэнээс санал авсан хангалтгүй үзүүлэлттэй байна.

Дэлхий нийтэд тархсан цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан иргэдийн саналыг биечлэн авах, хурал уулзалт зохион байгуулах боломжгүй байсан хэдий ч журамд тусгагдсан цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрээр иргэдийн оролцоог хангах боломжийг ашиглаагүй байна. Сум, багийн Засаг дарга нар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний саналыг авахдаа иргэдийн идэвх санаачилга, бүтээлч оролцоог дэмжиж, төр иргэний хамтын ажиллагааг нэмэгдүүлснээр иргэд орон нутагтаа тулгамдаж буй асуудлаа өөрсдийн оролцоотойгоор тодорхойлох, төлөвлөх, улмаар иргэдийн дэмжлэг хүлээсэн, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн шийдвэр гаргах сайн үр нөлөөтэй.

<sup>7</sup> 63 дугаар зүйл.Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах

<sup>8</sup> 63.1.Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна

<sup>9</sup> 63.2.Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

<sup>10</sup> 63.3.Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

<sup>11</sup> 63.4.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална.

Аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд нийт 12,845.2 сая төгрөгийн өртөгтэй 274 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан бөгөөд “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.4<sup>12</sup> дахь заалтыг зөрчиж, алслагдсан багийн иргэдээс хамгийн олон санал авсан ТАХ-г ИТХ-аар батлаагүй, баталсан боловч хэрэгжүүлээгүй байна. /Хавсралт №2/


**Илрүүлэлт:**

- ✓ Алтай, Баян-Уул, Бигэр, Жаргалан, Тонхил, Хөхморьт, Цогт, Цээл, Эрдэнэ, Есөнбулаг сумд нь алслагдсан багийн иргэдээс хамгийн олон саналыг авсан төсөл, арга хэмжээг баталж хэрэгжүүлээгүй.

Иргэдээс давхардсан тоогоор 79,899 санал ирснээс 20,366 санал авсан 221 ТАХ-г батлан хэрэгжүүлж, 59,533 санал авсан 794 ажил цуцлагдсан байна. /Хавсралт №02/ Төсвийн тухай хуулийн дугаар зүйлийн 60.3.6<sup>13</sup>, “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.7.5<sup>14</sup>-д зааснаар орон нутгийн иргэдийн саналыг аваагүй ТАХ нь нийтийн эрх ашигтай нийцээгүй, зарцуулахыг зөвшөөрөхгүй зардал юм.

Тайлант онд хэрэгжүүлэхээр ИТХ-аар хэлэлцэж баталсан нийт 12,932.8 сая төгрөгийн 279 ТАХ-ний 65 хувь буюу 8,378.4 сая төгрөгийн 118 төсөл арга хэмжээ нь иргэдийн санал аваагүй байна. Энэ нь төсвийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлэх, иргэдийн төсвийн шийдвэр гаргахад оролцох боломжийг ОНХС-аар дамжуулан олгож байгаа төсвийн харилцааны шинэчлэлийн үнэ цэнийг гажуудуулж байна. /Хавсралт №3/

*Дүрслэл 2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын санал авсан, эрэмбэлсэн байдал /сая.төг/*



*Эх сурвалж: Аудитын ажлын баримт*

Түүнчлэн иргэдийн санал аваагүй арга хэмжээг баталж, санхүүжүүлэх нь нийтийн эрх ашигт нийцээгүй шийдвэр гарах, бодит хэрэгцээ, шаардлагад үндэслээгүй хөрөнгө оруулалт бий болох эрсдэлийг бий болгож байна.

**Илрүүлэлт:**

- ✓ Аймгийн ОНХС-аас иргэдээс санал аваагүй 7,170.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.
- ✓ Алтай, Бигэр, Бугат, Дарив, Тайшир, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Чандмань, Эрдэнэ, Есөнбулаг сумд нь иргэдээс санал аваагүй 1,208.1 сая төгрөгийн 77 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

12 4.3.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;

13 60.3.6. орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

14 4.3.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг 7 хөтөлбөр, 107 зорилтын хүрээнд баталжээ. Мөн тус өдрийн 11 дүгээр тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” бодлогын баримт бичгийг баталсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.4<sup>15</sup> дэхь заалттай нийцсэн байх шаардлагатай.

#### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ

Төсвийн тухай хуульд хөтөлбөр, хөрөнгө оруулалт, арга хэмжээг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

4.1.16. “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг;

4.1.17. “арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;

4.1.24. “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

Тус онд батлагдсан нэг хөрөнгө оруулалтын ажлыг эс тооцвол ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан бусад төсөл арга хэмжээ нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

#### Илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн урт богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй "Дашпэлжээлин хийдийн өргөтгөлийн барилгын суурийн угсралт"-ын ажлыг ИТХ-аар баталж санхүүжүүлсэн байна.

1.2.3. ОНХС-аас Засаг даргын чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.4 дэх хэсэгт аймаг, сум өөрийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүргийг тусгажээ. Энэ зүйлийг 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан боловч 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны төлөвлөлтийн үе шатны ажил дээрх хуулийн заалт хүчин төгөлдөр байсан цагалбарт хугацаанд хамаарч байна. Аймгийн ОНХС-ийн тухайд 7,540.7 сая төгрөгийн 42 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас Төсвийн тухай хуулийн

- 58.2.13-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиг үүргийн хүрээнд 1,388.0 сая төгрөгийн 10 ТАХ-г
- 58.2.15-т заасан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд 964.0 сая төгрөгийн 2 ТАХ-г
- 58.2.16-т заасан аймгийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг хангах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд 104.0 сая төгрөгийн 2 ТАХ-г
- 58.2.17-т заасан энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын байрлаж байгаа орон нутгийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтын чиг үүргийн хүрээнд 1,751.0 сая төгрөгийн 3 ТАХ-г
- 58.2.20-т заасан хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 3,333.0 сая төгрөгийн 25 ТАХ-г хэрэгжүүлэхээр тус тус баталсан.

15 6.3.4. орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;


ОНХС-ийн 2021 оны хөрөнгөөр хэрэгжүүлэхээр сумын ИТХ-аар хэлэлцэж баталсан нийт 5,392.0 сая төгрөгийн 237 ТАХ-г Төсвийн тухай хуулийн заалтаар ангилж үзвэл сумын тохижилтын 21 ажилд 348.5 сая төгрөгийн, усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох 22 ажилд 1,299.7 сая төгрөгийн, орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх 17 ажилд 979.2 сая төгрөгийг, хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд 108 ажилд 1,400.7 сая төгрөгийг баталсан нь нийт ТАХ-ны 75 хувийг эзэлж байна.

#### 1.2.4. Зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсаар байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>16</sup>, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3, “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3<sup>17</sup>-т заасан төлөвлөлтийн шаардлагын үндсэн нөхцлийг хангасан байх ёстой.

Тус хууль, журмын заалтад нийцээгүй 10,144.9 сая төгрөгийн 197 ТАХ-г хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталсан нь нийт төсөл арга хэмжээний 78 хувийг эзэлж байна. /Хавсралт №4/

*Дүрслэл 3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан ажлын төлөвлөлтийн шаардлага хангасан байдал /сая.төг/*



Эх сурвалж: Аудитын ажлын баримт

#### Илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгавар, зураг төсөвгүй 7,540.7 сая төгрөгийн 42 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.
- ✓ Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Тонхил, Төгрөг, Халиун, Цогт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ, Есөнбулаг буюу нийт 16 сум техник эдийн засгийн үндэслэл, ажлын даалгавар, зураг төсөвгүй 2,604.2 сая төгрөгийн 155 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ажлын даалгавар, зураг төсөв, ТЭЗҮ-ийг урьдчилан боловсруулахгүй батлах нь худалдан авах ажиллагаа зохион байгуулахад хугацаа алдах, ТАХ-ний гүйцэтгэл он дамжих, цаашлаад ард иргэдийн өгөөж хүртэх хугацаа хойшлох зэрэг үр дагаварт хүргэхээр байна.

16 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

17 4.3.3 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

## **БҮЛЭГ 2. ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧАНАР, АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ ЗОХИСГҮЙ БАЙГАА ХЭДИЙ Ч ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЖ ЧАНАРТАЙ АЖЛУУД НЬ ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХЭЭР БАЙНА.**

### **2.1. БОСГО ҮНЭЭС ДАВСАН АЖИЛД ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ЗАРЛААГҮЙ, ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛЖ БАЙНА.**

#### **2.1.1. Босго үнээс давсан 8 төсөл арга хэмжээг ХАА зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.**

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 3.3.7, 3.4.4-т зааснаар ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжих бараа, ажил үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах хяналт тавих нь аймаг, сумдын Засаг даргын чиг үүрэгт хамаарна.

МУЗГ-ын 2021 оны 124 дүгээр тушаалаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг шинэчлэн баталсан.

ОНХС-ийн 2021 оны эх үүсвэрээр 12,932.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 279 ТАХ-г хэрэгжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталснаас 10,698.7 сая төгрөгийн 214 ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнээс урсгал зардал болон босго үнээс доош 2,203.1 сая төгрөгийн 153 ТАХ, худалдан авах ажиллагаа зарлах 7,544.5 сая төгрөгийн 61 ТАХ байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт ажлын 42 хувь буюу 27 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 33 ажлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 1 ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулсан. Худалдан авах ажиллагаа зохион байгуулснаар 422.9 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гаргасан байна. /Хавсралт №5/

Тус онд аймаг, сумдын ОНХС-аар хэрэгжүүлсэн босго үнээс давсан 360.9 сая төгрөгийн 8 ТАХ-г хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн.

#### Илрүүлэлт:

- ✓ Аймгийн ОНХС: Босго үнээс давсан 154.9 сая төгрөгийн 2 ажилд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн.
- ✓ Аймгийн ОНХС: Газар тариалан жимс жимсгэнэ хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн ТЭЗҮ боловсруулах төсөл арга хэмжээг шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны 1 гишүүний А-3 сертификат дууссан байхад гишүүнээр томилсон.
- ✓ Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Цээл, Чандмань сумдын ОНХС: Босго үнээс давсан 152.0 сая төгрөгийн 8 ажилд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн
- ✓ Халиун сумын ОНХС: Үнэлгээний хорооны 2 гишүүний А3 эрх дууссан байхад гишүүнээр томилсон.
- ✓ Чандмань сумын ОНХС: Үнэлгээний хорооны гишүүд журмын дагуу ажиллаагүй, тендерийг үнэлсэн, ашиг сонирхлын байдлаа илэрхийлсэн мэдэгдэлгүй, урилга, үр дүнг цахимаар мэдээлээгүй байна.
- ✓ Эрдэнэ сумын ОНХС: Сумын ЗДТГ-т авто машин худалдан авах үнэлгээний хорооны нэг гишүүн /төлөөлөгч/ нь А3 сертификатгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх босго үнээс давсан ТАХ-г худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй шууд гэрээ байгуулж, ХАА-г ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдлөг болгож ажиллаагүйн улмаас сангийн өмч хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, чанаргүй бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгдэхээр байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлд сумын түвшинд 20 сая төгрөгөөс хэтрэхгүй төсөвт өртөгтэй, тусгай зөвшөөрөл шаардахааргүй бараа, ажлыг иргэдийн бүлгээр буюу олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар гүйцэтгүүлж болохоор журамласан. Иймд аль болох өрсөлдөөнийг хязгаарласан шууд гэрээ байгуулах аргаас зайлсхийж, сангийн бүхий л үе шатанд орон нутгийн иргэдийн оролцоог хангаж, төслийн хэрэгжилтийг ил тод, нээлттэй болгох шаардлагатай байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг төсвийн байгууллагын урсгал зардал, ИТХ-аар батлагдаагүй ТАХ, нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дэх хэсэгт аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлсон байна.

Засгийн газрын 2021 оны 183 дугаар тогтоолын 2-т "Аймаг, сумдын баяр наадам, хурдан морины уралдаан, уул, овооны тахилга, тэмдэглэлт ой зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байхыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосон. Гэвч дараах 4 сумд баяр наадам тэмдэглэж зарцуулалт гаргасан байна.

**Илрүүлэлт:**

- ✓ Бугат, Дарив, Төгрөг, Есөнбулаг сумд Засгийн газрын тогтоолоор аймаг, сумын баяр наадам тэмдэглэхийг хориглосон байхад 17.0 сая төгрөгийн зардал гаргасан
- ✓ Цогт сумын ОНХС: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж ЗДТГ-ын автомашинд 3.6 сая төгрөгийн сэлбэг худалдаж авсан.
- ✓ Шарга сумын ОНХС: "Газар тариалан жимс жимсгэнэ хөтөлбөр"-ийн хүрээнд мал худалдан авсан, иргэнд 5.8 сая төгрөгийн цалингийн зардал олгосон.

Мөн ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г бөөн дүнгээр багцалж хөтөлбөр нэрээр баталсан нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, улмаар төсвийн байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэх, шагнал урамшуулалд зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Боловсролын чанарыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг баталж 2021 онд 116.5 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнээс элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан багш сурагчдыг урамшуулах, багш нарын улсын уралдаанд амжилттай оролцсон багш нарыг шагнах, шилдэг сургууль, сайн хичээлийг шалгаруулж урамшуулах зэрэг арга хэмжээнд нийт 67.4 сая төгрөгийг зарцуулжээ.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д зааснаар "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ"-г санхүүжүүлэхийг хориглодог.

**Илрүүлэлт:**

- ✓ Баян-Уул сумын ОНХС: Он дамжин хэрэгжсэн баатар вангийн хөшөө засвар тохижилтын ажлын санхүүжилт болох 3.4 сая төгрөгийг олгосон
- ✓ Халиун сумын ОНХС: Өмнөх оны үлдэгдэл ажил болох хөв байгуулах ажлыг ИТХ-аар батлаагүй байхад үлдэгдэл санхүүжилт болох 0.8 сая төгрөгийг олгосон.

## 2.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨГ УРТ ХУГАЦААНД ТОДОРХОЙЛОХООР БАЙНА.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр өгөөжийг урт хугацаанд үнэлэхээр байна.

*Хүснэгт 3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ /сая.төг/*

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Санхүүжилт
1	Боловсролын чанарыг дээшлүүлэх хөтөлбөр	500.0	116.5
2	Газар тариалан жимс жимсгэнэ хөтөлбөр хэрэгжүүлэх	1,387.9	1,333.5
3	Сумын төвийн шинэчлэл дэд бүтэц хөдөөгийн хөгжил	2,819.4	744.0
4	Бусад арга хэмжээ /Зураг төсөв/	2,833.5	1,559.5
	Нийт дүн	7,540.73	3,753.60

*Эх үүсвэр: Аудитын ажлын баримт*

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн ТАХ-ны тухайд:

- Газар, тариалан жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд 1,387.9 сая төгрөгийн санхүүжилтийг баталж 2021 онд гүйцэтгэлээр 1,333.5 сая төгрөгийг зарцуулжээ. Алим, жимс жимсгэнэ, бүх төрлийн хүнсний ногоо, үр тариа, малын ногоон тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлж, хүн амыг эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр ханган, нутгийн брэнд бүтээгдэхүүнийг шинээр бий болгох, түүнчлэн тогтвортой ажлын

байрыг нэмэгдүүлэх замаар иргэдийн орлогыг бодитойгоор дэмжих зорилт тавьсан, 2021 онд сайн дурын 6-7 хүний бүрэлдэхүүнтэй 42 бүлэг байгуулагдан, 320 тариаланчийн ажлын байр баталгаажжээ. /Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн тайлан/

Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 4 жилийг хамарсан тул үр дүн, үр ашгийг энэ онд дүгнэхээргүй байна.

- “Сумдын шинэчлэл-хөдөөгийн хөгжил” төслийн хүрээнд 17 сумд 120 айлын цогцолбор бүхий хотхон байгуулах зураг төсөв, инженерийн шугам сүлжээний дэд бүтцийг шийдвэрлэхэд гүйцэтгэлээр 914.5 сая төгрөгийг зарцуулжээ. Сумын төвийн шинэчлэлийн ажлыг үр дүнтэй, үе шаттайгаар хэрэгжүүлснээр иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулах, цаашлаад төвлөрлийг сааруулах томоохон ажлыг эхлүүлсэн хэдий ч 2021 онд 2,944.0 сая төгрөгийн гэрээтэй 4 ажлын гэрээний хугацааг сунгасан, ажлын явц удаашралтай байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр он дамжиж хийгдэж байгаа төсөл, хөтөлбөрийн тухайд үр ашиг, үр нөлөөг үнэлэх шалгуурыг тодорхой болгох шаардлагатай.

Аймгийн ОНХС, сумдын ОНХС эхэлснээс хойш хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг нэгтгэн харахад Алтай хотын телекамерын хяналтын системийг сайжруулах, нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 337.6 сая төгрөгийн зарцуулжээ. Аудитаар газар дээр нь үзэхэд өмнөх онуудад хийгдсэн ажлын чанар байдал муу, дахин 2021 онд 79.7 сая төгрөгөөр камержуулалт хийжээ.

Мөн Есөнбулаг сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2013-2021 онуудад 53.8 сая төгрөгөөр инженерийн шугам сүлжээний траншейг тагжуулах ажил хийгдсэнээс 2013 оны төслийн байршил, бүртгэл тодорхойгүй, 2022 оны Есөнбулаг сумын ОНХС-аар хэрэгжүүлэхээр дахин 50.0 сая төгрөг төсөвлөсөн байна.

*Хүснэгт 4. Олон давтамжтай хэрэгжсэн ТАХ*

№	Төсөл, хөтөлбөрийн нэр	Хэрэгжсэн он	Санхүүжилт /сая.төг/
1		2013-2014	144.4
2	Алтай хотын телекамерын хяналтын системийг сайжруулах	2018	93.5
3		2020	20.0
4		2021	79.7
		Нийт дүн	
1	Есөнбулаг сумын инженерийн шугам сүлжээний траншейг тагжуулах, эвдэрсэн газар, гуу жалгыг тэгшлэх	2013	15.0
2		2020	38.8
3		2022	50.0
	Нийт дүн		103.8

*Эх сурвалж: Аудитын ажлын баримт*

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлууд нь орон нутагт иргэд ая, тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж байна.

Аймгийн ОНХС-ийн 2014-2017 оны 2,990.0 сая төгрөгийн эх үүсвэрээр Есөнбулаг сумын Баянхайрхан багийн 11-р гудамжны ар талыг шинэ суурьшилын бүс болгох ажлын хүрээнд “Солонго” 1000 айлын орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэсэн. Шинэ суурьшлын бүсэд нийтийн орон сууц, амьны хаус, сургууль, цэцэрлэг, усан бассейн, дулааны станц баригдаснаар орон нутгийн иргэдийн тав, тухтай ажиллах, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлсэн, ОНХС-ийн зорилгод нийцсэн хөрөнгө оруулалтын томоохон ажил болсон байна. /Зураг 2/

Аймгийн 2019 оны ОНХС-ийн 40.0 сая төгрөгийн эх үүсвэрээр Жаргалан сумын “Суурин дулаан” ААТҮГ-ын уурын зуухны тогоо, тоног төхөөрөмжийн эх үүсвэрийг шийдвэрлэснээр сумын төвийн 13 төсөвт байгууллага, ААН, 22 айл өрхийг төвлөрсөн дулааны эрчим хүчээр хангаж байна. /Зураг 3/

Зураг 2. Алтай хотын шинэ суурьшлын бүс



Зураг 3. “Суурин дулаан” ААТҮГ



### 2.3. ОНХС-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ЗАРИМ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгө ашиглалтгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" гэж заасан.

ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн малжуулах ажлын хүрээнд малыг малчдад гэрээгээр өгч авсан малаа зүс, хувийн дугаараар болон тодорхой хувийг залуужуулж дараагийн малчинд хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулдаг.

#### Илрүүлэлт:

- ✓ Алтай сумын ОНХС: Гэрээгээр олгосон 39.2 сая төгрөгийн 245 толгой хонь 105 толгой ямаа 22 толгой сарлагийн гэрээнд олгосон малын тоо толгойг тодорхой тусгаж өгөөгүй
- ✓ Алтай сумын ОНХС: Гэрээгээр олгосон 2.1 сая төгрөгийн 6 толгой сарлагийн гэрээний хугацаа дууссан байхад хүлээн авч дараагийн айлд шилжүүлээгүй.

Аймгийн ОНХС-ийн 2013-2021 оны эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудаас түүвэрлэн хадгалалт, хамгаалалтыг газар дээр нь үзэж танилцахад дараах хөрөнгө оруулалтууд ашиглах боломжгүй болсон байна. Тухайлбал

- Аймгийн 2017 оны ОНХС-ийн 59.5 сая төгрөгийн санхүүжилтээр нийлүүлсэн хог ачих автомашин 6 сар ашиглаад эвдэрсэн, ашиглалтгүй /Зураг 4/
- Аймгийн 2018 оны ОНХС-ийн 93.5 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн “Алтай хотын телекамерын хяналтын системийг сайжруулах, камерын тоо нэмэгдүүлэх” ТАХ-г хадгалалт хамгаалалтыг хариуцах байгууллага тодорхойгүй, камер ажилладаггүй
- Аймгийн 2020 оны ОНХС-ийн 282.7 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн “Хогийн цэгийн бункер шинэчлэх, авто машины парк шинэчлэлт” ажлаас 6 хогийн сав шатаж, 2 хогийн сав хагарсан, автомашин халалт ихтэй, хүчин чадал муу учраас ашиглалтгүй /Зураг 5/
- Дарив сумын 2020 оны ОНХС-ийн 32.9 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн “Сургуулийн хөл бөмбөгийн талбай барих” ТАХ-ний тухайд талбайн гадна торон хашаа салж эвдэрсэн, хиймэл зүлэг хуурч, шрупа салсан /Зураг 6/
- Дарив сумд 2014-2016 онд хийсэн 349.0 сая төгрөгийн уурын зуур нийгмийн хэрэгцээг хангаагүй үр дүнгүй ажил болсон байхад эдийн засгийн эргэлтийг тооцоогүй орхигдуулсан байна.

Зураг 4. Хог тээврийн автомашин



Зураг 5. Хогийн бункер, автомашин



Зураг 6. Хөлбөмбөгийн талбай




2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр 2013 оноос хойш хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад ард иргэд, нутгийн удирдлага, төрийн байгууллагын оролцоо нэн чухал байна. Нэг талаас иргэдийн ухамсар муу, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэлж сүйтгэдэг, нөгөө талаас ашиглалт, хамгаалалтыг хариуцаж байгаа байгууллагад урсгал засварын зардал төсөвлөдөггүй, засвар үйлчилгээг хийх мэргэжлийн боловсон хүчин дутмаг зэрэг олон шалтгаанаас хөрөнгийн насжилт, үр өгөөж хүртээх хугацаа богиносж, дахин урсгал засвар, үйлчилгээ хийх шаардлага бий болжээ.

Аймгийн ОНХС-ийн 2013-2021 оны эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудаас түүвэрлэн хадгалалт, хамгаалалтыг газар дээр нь үзэж танилцахад 1,195.0 сая төгрөгийн 11 ажлын чанар байдал хангалтгүй, эвдэрч хэмхэрсэн байдалтай байна. Тухайлбал:

- Аймгийн 2016 оны ОНХС-ийн 6.0 сая төгрөгийн санхүүжилтээр Жаргалант, Баарангийн даваанд мод тарьсан, ургаагүй
- Аймгийн 2017 оны ОНХС-ийн 82.8 сая төгрөгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн “Шүтээний өндөрлөг цогцолборын их засвар”-ын ажлаас гэрэлтүүлэг бүгд хагарсан, усан оргилуурын мотор шатсан, 4 талын камер эвдэрсэн, плита хагарсан, харуулын байрны цонх хагарсан /Зураг 7 /
- Аймгийн 2017 оны ОНХС-ийн 199.0 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн “Сайн байна уу? хаалганы үсгүүд унасан, плита хагарсан
- Аймгийн 2018 оны ОНХС-ийн 121.2 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн “Төв стадионыг хэсэгчилсэн их засварт оруулах” ТАХ-ний тухайд үзэгчдийн суудлын шавар нурсан, шинээр суурилуулсан 33 сандал хагарсан, асарт ус орсноос будаг ховхорсон /Зураг 8/
- Аймгийн 2018 оны ОНХС-ийн 1,776.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Жаргалан багийн гэр хорооллын хатуу хучилттай автозам барих ажил”-ын Баяншанд багийн дээд хэсэгт хучилт нимгэн, зарим хэсэг хонхойсон, хүлээлгэж өгөөгүй байгаа
- Аймгийн 2020 оны ОНХС-ийн 295.7 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдсэн “Алтай хотын гэр хороололд явган хүний зам тавих” ажлаас Индэрт багийн явган хүний замын хавтан хагарч, цөмөрсөн, Шүтээний өндөрлөгийн зүүн талын хэсэг хагарсан /Зураг 9/
- Есөнбулаг сумын 2021 оны ОНХС-ийн 20.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Жанчивын талбайн тохижилт”-ын ажил өнгө үзэмж муутай

Зураг 7. Шүтээний өндөрлөг



Зураг 8. Төв стадионы засвар



Зураг 9. Явган хүний зам



Мөн сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 135.9 сая төгрөгийн том оврын ковш, олон үйлдэлт тракторууд эвдэрч ашиглалтаас гарсан, 506.0 сая төгрөгийн хөрөнгийг хувь хүмүүст

харилцан адилгүй гэрээ байгуулан ашиглуулж байгаа нь иргэд олон нийт хөрөнгийн үр өгөөжийг тэгш хүртэхгүй байна.

### **БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНААГҮЙ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙГ ҮНЭН ЗӨВ, ИЖ БҮРЭН МЭДЭЭЛЛЭЭР ХАНГААГҮЙ БАЙНА.**

**3.1. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮЖИЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦАД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**

3.1.1 Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний үр дүнд тавих хяналт хэрэгжүүлээгүй байна.

"ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 9.4-т ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хороо хяналт тавьж ажиллахаар зохицуулсан.

ОНХС-ийн эх үүсвэрээр хяналт тавивал зохих 8,572.0 сая төгрөгийн 246 ТАХ хэрэгжсэн байна. Аудитаар аймаг, сумдын ИТХ-ын дэргэд Хяналтын хороо байгуулж хяналт тавьсан эсэхийг үзэхэд дээрх журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийт хяналт тавивал зохих ТАХ-ны 30 хувь буюу 5,646.4 сая төгрөгийн 75 арга хэмжээнд хяналт тавьж ажиллаагүй байна.

#### **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын

2.1.1-т “Хяналт-шинжилгээ” гэж байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилт, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг;

2.1.2-т “Үнэлгээ” гэж байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн

#### **Илрүүлэлт:**

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 21 хөтөлбөр төсөл арга хэмжээнд хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй.
- ✓ Алтай, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тонхил, Есөнбулаг сумд нь нийт 54 төсөл арга хэмжээнд хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй.

3.1.2. Захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээр хөрөнгө оруулалтын ажил гэрээт хугацаанд хийгдэхгүй удааширч, төсвийн хөрөнгө үнэгүйдэж, ард иргэдийн хүртэх үр өгөөж буурч байна.

"ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 8.6<sup>18</sup>-д зааснаар сумын хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг

#### **Илрүүлэлт:**

- ✓ Хөхморьт сумын ОНХС: Өвс тэжээлийн нөөц нэмэгдүүлэх ажлын хүрээнд бэлтгэсэн 10.0 сая төгрөгийн хивгийн хадгалах хугацаа дууссан байна.
- ✓ Хөхморьт сумын ОНХС: Хог тээврийн машины авто тээврийн хэрэгслийн гэрчилгээг шилжүүлээгүй, нийлүүлэгчийн нэр дээр өмчлөлтэй байна.

Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна. Дараах сумдад хяналт

#### **Илрүүлэлт:**

- ✓ Бигэр, Бугат, Дарив, Жаргалан, Төгрөг, Шарга, Эрдэнэ сумдын ОНХС-ийн төрийн сан дахь данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад санхүүгийн албаны дарга нь гарын үсэг зурж байна.

18 8.6.Энэхүү журмын 8.5-д заасан санхүүжилтийн эрхийн дагуу ОНХС-ийн төрийн сан дахь данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад ..... сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна.

тавих эрх бүхийн албан тушаалтан буюу санхүүгийн албан дарга төлбөрийн хүсэлтийн баримтад гарын үсэг зурж байгаа нь журмын дээрх заалттай нийцэхгүй байна.

"ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 3.2.2<sup>19</sup>, 3.3.3<sup>20</sup> дахь хэсэгт зааснаар ТАХ-ны хэрэгжилтэд аймаг, сумдын Засаг дарга хяналт тавих чиг үүрэгтэй.

Захиалагчийн хяналт тавивал зохих нийт 8,572.0 сая төгрөгийн 246 ТАХ-ны 17 хувь буюу 5,119.4 сая төгрөгийн 41 ТАХ-нд захиалагчийн явцын хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Илрүүлэлт:

- ✓ Алтай, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тонхил, Есөнбулаг сумд нь нийт 48 төсөл арга хэмжээнд хяналтын хороо хяналт тавьж ажиллаагүй.
- ✓ Хөхморьт сум нь 8 төсөл арга хэмжээний санхүүжилтээс гэрээнд тусгаагүй 0.6 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал суутгаж зарцуулсан байна.
- ✓ Есөнбулаг сум нь Мал эмнэлгийн бакерийн байгууламж бий болгох ажлын санхүүжилтийг 0.3 сая төгрөгөөр илүү олгосон.
- ✓ Дэлгэр сум нь "Шинээр худаг гаргах" ажлын гүйцэтгэгчид гэрээний дүнгээс 0.6 сая төгрөгийн санхүүжилтийг илүү тооцож олгосон байна.

Захиалагчийн зүгээс гэрээний хэрэгжилтэд хяналт тавиулахаар томилсон ажлын хэсэг нь хяналт хийх төлөвлөгөө, хуваарийг боловсруулж, баталсан хуваарийн дагуу ажлын гүйцэтгэлтэй тогтмол танилцаж, гүйцэтгэгч хуваарийн дагуу ажлын явц үргэлжилж буй эсэх техникийн тодорхойлолтод тусгасны дагуу бараа, ажил, үйлчилгээ хийгдэж байгаа эсэх, ажил, үйлчилгээнд ашиглагдаж буй бараа материалын чанар, тоо ширхэг зэргийг хянаж байх шаардлагатай.

Захиагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, нэр төдий хэрэгжүүлснээс ТАХ зорилтот түвшиндээ хүрэхгүй чанаргүй, дутуу хийгдэх, гэрээт хугацаанд хийгдэхгүй удааширч ард иргэдийн өгөөж хүртэх хугацаа хойшилж байна.

Илрүүлэлт:

- ✓ Алтай сумын ОНХС: Хаягжуулалт, мал эрүүлжүүлэх төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй байхад арга хэмжээ авч ажиллаагүй
- ✓ Дарив сумын ОНХС: Гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөгүй 14.2 сая төгрөгийн 3 ажил байна.
- ✓ Дэлгэр сумын ОНХС:Цэцэрлэгийн гадна талбайн тохижилт, Бэлийн худгийн засвар, шинэ халуун ус барих, камержуулалт, өвс тэжээлийн аюулгүй нөөц, Гуулин тосгонд өвс тэжээлийн фонд барих төсөл арга хэмжээний гэрээний эхлэх болон дуусах огноог тусгаагүйгээр давуу эрх олгож гэрээг байгуулсан байна.

Илрүүлэлт:

- ✓ Дэлгэр сумын ОНХС: Шинээр 2 худаг гаргах, бакерийн нүх, 0.4 шугам, Үзүүрийн худаг, Босгын худгийн засварын ажлыг гэрээнд хугацаанд хүлээн аваагүй байна.Жаргалан сумын ОНХС:Наадмын талбайн засвар, гамшгийн сангаас түргэвчилсэн оношлуурыг гэрээт хугацаанд хүлээн аваагүй байна.
- ✓ Жаргалан сумын ОНХС: Ногоон байгууламжид ашиглах тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлыг хүлээж авахдаа "суурин байрлуулах усан сан буюу ёмкост" нийлүүлээгүй байхад хийгдснээр хүлээн авсан байна.Тайшир сумын ОНХС: Жишиг гудамжны гэрэлтүүлэг, Хадлангийн талбайн тариалалт, зураг төсөв, бакерийн нүх хийх ажлыг гэрээт хугацаанд хүлээн аваагүй байна.
- ✓ Тонхил сумын ОНХС: Халуун усны барилга барих 59.0 сая төгрөгийн ажлыг гэрээт хугацаанд хүлээлгэн өгөөгүй байна.
- ✓ Халиун сумын ОНХС: Олон булаг багт инженерийн хийцтэй худаг гаргах, Нэгдсэн халаалтын өргөтгөл хийх төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй байхад арга хэмжээ авч ажиллаагүй

Аудитаар 2013-2020 оны аймгийн ОНХС, сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ТАХ-ны нэгдсэн судалгаа хийхэд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, санхүүжилт олгосон ч өнөөдрийг хүртэл гэрээг дүгнэж хүлээж аваагүй 2,820.7 сая төгрөгийн 23 ажил байна. Үүнээс 267.8 сая

19 3.2.2.Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

20 3.4.3.Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

төгрөгийн 7 ажлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, 2,552.8 сая төгрөгийн 16 ажил нь гэрээний дагуу арга хэмжээ аваагүй нөхцөл байдалтай байна. /Хавсралт №6/

**Илрүүлэлт:**

- ✓ Өмнөх онуудад аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 2,130.9 сая төгрөгийн 7 ажил, сумдын 410.0 сая төгрөгийн 9 ажлыг гэрээний хугацаанд хийж гүйцэтгээгүй, хэрэгжилт дутуу, үр дүн хангалтгүй байхад захиалагч, орон нутгийн захиргааны байгууллага тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Алтай сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд 345.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт заалны барилга барих ажлын гэрээ байгуулж, гүйцэтгэгчид 168.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч суурийн ажил цутгагдсан одоог хүртэл ажил хийгдээгүй байна. Тэгвэл Эрдэнэ сум нь 2019-2021 оны ОНХС-ийн эх үүсвэрээр 279.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт заалыг барьж ашиглалтад оруулсан байна. Захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлснээр хөрөнгө оруулалтын ажлыг гэрээт хугацаанд хүлээж авсан, санхүүжилтийг 3 онд хуваарилж баталснаар сангийн төсөвт дарамт учруулахгүйгээр үр өгөөжтэй бүтээн байгуулалт хийсэн сайн жишээ байна.

Зураг 10. Эрдэнэ сумын Спорт заал

Зураг 11. Алтай сумын Спорт заал



Тайлант 2021 онд ОНХС-ийн аймаг, сумдын төрийн сан дахь данснаас нийт 6,901.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээ гарснаас 2,424.6 сая төгрөгийн и-баримтгүй гүйлгээг баталж санхүүжүүлсэн байна. Төрийн байгууллагад гэрээгээр бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлж байгаа иргэн, ААН-д санхүүжилтийг төлбөрийн баримтад үндэслэж олгосноор төсвийн орлогын найдвартай, тогтмол эх үүсвэрийг бүрдүүлэх, далд эдийн засгийг татварт хамруулах хэрэгсэл болох НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг болохоор байна.

**Илрүүлэлт:**

- ✓ И-баримтгүй 2,424.6 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

3.1.3. Журамд заасан дотоод хяналт шалгалтыг хийхгүйгээс зөрчил жил бүр давтагдан гарсаар байна.

“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-т зааснаар тухайн шатны дотоод аудитын нэгжээс хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Аймгийн ТЕЗ-ын дотоод аудитын нэгжээс ОНХС-ийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-нд хяналт тавьж ажиллаагүй байна. Өөрөөр хэлбэл Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10<sup>21</sup>, 69 дүгээр зүйлийн 69.1<sup>22</sup> дэх хэсэгт заасан ТЕЗ-ийн дотоод аудитын нэгж нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.

<sup>21</sup> 14.2.10. өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

<sup>22</sup> 69.1 Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт,

Хүснэгт 5. ТА-3 төслийн 2021 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээ

Тогтвортой амьжиргаа-3 төслөөс сайн засаглал-үр дүнд суурилсан урамшууллын

хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон бие даасан хөндлөнгийн үнэлгээний баг сумдын засаглалын төвшнийг олон нийтийн оролцоо, сумын төсвийн төлөвлөлт, төсвийн ил тод байдал, төсвийн гүйцэтгэл, хяналт-шинжилгээ үнэлгээ, өмчийн удирдлага гэсэн 6 бүлэг үзүүлэлтээр тодорхойлжээ.

ТА-3 төслийн 2021 оны жилийн гүйцэтгэлийн үнэлгээний тайлангийн үзүүлэлтээс харахад Төгрөг сум дундаж үнэлгээгээр 84 хувь буюу хамгийн өндөр үнэлгээтэй, Алтай, Есөнбулаг сумд 40 хувь буюу хамгийн бага үнэлгээтэй байна.

Ил тод байдал, гүйцэтгэл, хяналт шинжилгээ үнэлгээ гэсэн үзүүлэлтүүд хангалтгүй түвшинд байгаа нь сумдын дундаж оноонд сөргөөр нөлөөлсөн гэж дүгнэхээр байна.

Сумын нэр	Олон нийтийн оролцоо	Төлөвлөлт	Ил тод байдал	Гүйцэтгэл	ХШҮ	Өмчийн удирдлага	Сумын Үнэлгээ
Алтай	58%	47%	35%	27%	13%	61%	40%
Баян-Уул	67%	72%	45%	84%	75%	75%	69%
Бигэр	29%	62%	54%	44%	40%	56%	51%
Бугат	23%	68%	51%	44%	45%	84%	54%
Дарви	89%	60%	5%	64%	24%	67%	52%
Дэлгэр	74%	74%	41%	28%	46%	83%	58%
Есөнбулаг	51%	45%	8%	32%	31%	88%	40%
Жаргалан	97%	75%	30%	73%	45%	88%	68%
Тайшир	86%	96%	84%	56%	64%	100%	82%
Тонхил	50%	80%	11%	22%	23%	25%	41%
Төгрөг	96%	93%	32%	100%	88%	97%	84%
Халиун	44%	64%	30%	30%	7%	50%	42%
Хөхморьт	95%	77%	49%	44%	89%	91%	74%
Цогт	83%	57%	62%	45%	71%	57%	60%
Цээл	79%	78%	59%	33%	53%	34%	58%
Чандмань	89%	75%	54%	42%	33%	58%	63%
Шарга	91%	76%	54%	50%	64%	94%	70%
Эрдэнэ	86%	79%	62%	32%	35%	45%	61%
Сумдын дундаж	71%	71%	43%	47%	47%	70%	59%

Манай аймгийн сумдын дундаж үзүүлэлт 59 хувьтай байгаа нь улсын дунджаас 4.4 хувиар доогуур байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас 2013-2020 онд ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудитыг 1 удаа, нийцлийн аудитыг 7 удаа, санхүүгийн тайлангийн аудитыг 5 удаа хийж дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ. Аудитаар нийт 4,853.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32,754.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 3,251.3 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлж, 46 албан тушаалтанд хариуцлага тооцуулж байсан. /Хавсралт №7/

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхэд төлбөрийн актаас 4,741.9 сая төгрөг буюу 98 хувь барагдсан, зөрчил арилгуулах албан шаардлагаас 31,706.5 сая төгрөг буюу 97 хувь, зөвлөмжөөс 3,251.3 сая төгрөг буюу 100 хувь нь биелэгдсэн байна.

Аймгийн ОНХС-ийн тухайд санхүүжилтийг үе шат бүрээр хянаж олгосон, ТАХ-ыг хүлээж авах комиссыг тухай бүр томилж ажиллуулсан ахиц дэвшил гарсан байна.

Нийт аймаг, сумдын хэмжээнд аудитаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллаж байгаа гэх боловч ТЭЗҮ, зураг төсөвгүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй ТАХ хэрэгжүүлэхээр баталдаг, ХАА-ны журам зөрчдөг, хөрөнгийг бүртгэлд тусгадаггүй зөрчлүүд жил бүр давтагдан гарсаар байна.

Энэ нь төрийн албанд мэргэшсэн, тогтвор суурьшилтай боловсон хүчин дутмагаас төрийн ажлын уялдаа холбоо, залгамж халаа муу, орон нутгийн сонгуулийн үр дүнгээр хариуцсан албан тушаалтан олон удаа солигддог, ажлын хариуцлага сул байгаатай холбоотой.

шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

Мөн Төрийн аудитын байгууллагаас бусад хяналт хийх эрх бүхий байгууллагууд журамд заасан хяналт шалгалтыг хийхгүй байгаа нь журмын хэрэгжилт хангагдахгүй байгаа нэг шалтгаан байж болохоор байна.

### 3.2. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ЗААВАР ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАЖ ХҮРГҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнаагүй. "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2<sup>23</sup>, 9.3<sup>24</sup>, 9.9<sup>25</sup>-т ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргах процессыг журамласан.

Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь дээрх журамд заасан ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлээгүй байна. Улмаар Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгж нь тайланд дүн шинжилгээ хийж, ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулах үйл ажиллагаанд доголдол үүсэхээр байна.

Мөн журмын 9.3-т аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулахаар тусгасан боловч журмын хэрэгжилтийг хангуулаагүй байна. Түүнчлэн тус дүгнэлт болон Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлж байхаар дээрх журмын 9.7-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн жинхэнэ албан хаагчийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнах хөтөлбөр, арга хэмжээг тусгаж ажлын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон зарим хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4<sup>26</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2<sup>27</sup> дахь хэсэг, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.12<sup>28</sup>-т хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын асуудлыг зохицуулсан байна.

Аймгийн ОНХС, сумдын 2021 оны ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлж, хүлээж авсан ТАХ-нээс 1,647.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

<sup>23</sup> 9.2. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

<sup>24</sup> 9.3. Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

<sup>25</sup> 9.9. Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана.

<sup>26</sup> Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...

<sup>27</sup> Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

<sup>28</sup> 9.12. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

Мөн 2013-2020 онд аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн 1,863.3 сая төгрөгийн 40 ажлыг данс бүртгэлд тусгасан эсэх нь тодорхой бус байгаа тул хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалалтыг тодруулахаар аймгийн ОНӨГ-т уламжлахаар шийдвэрлэлээ.

**Илрүүлэлт:**

- ✓ Аймгийн ОНХС нь хүлээж авсан төсөл арга хэмжээнээс 1,400.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.
- ✓ Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр өмнөх онуудад хийгдсэн төсөл арга хэмжээнээс 440.0 сая төгрөгийн зураг төсөв, 65.3 сая төгрөгийн хайс болон ногоон байгууламж, 208.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, 0.1 сая төгрөгийн худаг, 151.6 сая төгрөгийн ЦДАШ, 878.1 сая төгрөгийн цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлуудыг бүртгэлд тусгасан нь тодорхойгүй байна.
- ✓ Баян-Уул, Бигэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Цээл, Чандмань, Шарга, Есөнбулаг сумдын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн нийт 246.9 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн төслийн хэрэгжилтийг дүгнэж, хөрөнгийг хүлээж авахдаа ирээдүйд тухайн хөрөнгийн ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагын төлөөллийг ажил хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд оруулж байх нь үр дүнтэй. Ажил, бараа, үйлчилгээ, хөрөнгийн зориулалт, шинж байдлаас хамааран аймаг, сумын ИТХ, Засаг дарга шийдвэр гарган эзэмшилт, ашиглалтын эрхийг сумын төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид шилжүүлэн данс бүртгэлд тусгаснаар хөрөнгийн удирдлага сайжирч төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг иргэд олон нийт илүү урт хугацаанд хүртэхээр байна.

**3.2.3. Удирдлагын мэдээллийн системд сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар иж бүрэн мэдээллийг оруулаагүйгээс иргэд, олон нийт үнэн зөв мэдээллээр хангагдахааргүй байна.**

Сангийн яамнаас 2020 онд “Тогтвортой амьжиргаа 3” төсөлтэй хамтран ОНХС-ийн “Удирдлагын мэдээллийн систем” буюу [www.tusuv-oronnutag.mof.gov.mn](http://www.tusuv-oronnutag.mof.gov.mn) цахим хуудсыг ашиглалтад оруулсан байна. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар хэсэгт тус системийн мэдээллийн агуулга, хүргэх хэлбэр, давтамж, хариуцах этгээд, мэдээлэл оруулах хугацааг тодорхой тусгажээ.

Иргэдийн хувьд энэ цахим хуудаснаас ОНХС-ийн талаарх видео, аудио, хэвлэмэл баримт бичгүүдийг үзэх, өөрийн болон бусад сумын ОНХС-ийн эх үүсвэрээр санхүүжсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг авах боломжтой гэх боловч анхан шатны нэгжээс мэдээллийг огт байршуулаагүй, иж бүрэн, үнэн зөв оруулаагүйгээс системийн мэдээлэл зүгшрээгүй байна. Тус онд 12,847.2 сая төгрөгийн 277 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас УМС-д оруулсан мэдээллийг 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар нэгтгэхэд 2021 онд аймгийн хэмжээнд 185 ажлын гүйцэтгэл 85 хувь, үүнээс тайлант онд ашиглалтад орох 152 ажил байна. Өөрөөр хэлбэл сумдын УМС-ийн “Иргэдийн санал”, “ИНХ-аас баталсан төслүүд, ажлын хэсэг эрэмбэлсэн тоо”, “ИТХ-аас хурлаас баталсан төслүүд”, “Төсөл арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл” цэсэд оруулсан тоо, баримтыг тулган баталгаажуулахад мэдээллийг үнэн зөв, иж бүрэн оруулаагүй байна.

Холбогдох албан тушаалтнууд мэдээлэл солилцож, аливаа төсөл хөтөлбөрийн хэрэгжиж буй эсэх асуудалд хяналт тавих боломжийг бий болгох, цаашид системээр дамжуулан мэдээллийн сан бүрдүүлж, хуваарилалт, төлөвлөлт хийх, төслийн санхүүжилт, гүйцэтгэлийг удирдах, тайлагнах, үнэлгээ хийх үндсэн зорилтоо хэрэгжүүлэх мэдээллийн суурь бааз бүрдээгүй, иргэд иж бүрэн мэдээллээр хангагдахааргүй байна.

**Илрүүлэлт:**

- ✓ Аймгийн ОНХС, Алтай, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань, Эрдэнэ, Есөнбулаг сумд нь Удирдлагын мэдээллийн системд мэдээлэл байршуулаагүй, иргэдийн саналыг зөрүүтэй оруулсан хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг мэдээлээгүй.

**3.2.4. ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцорч мэдээлсэн байна.**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцорч мэдээлсэн байна.

## **ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЕ ШАТ БҮРД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ, ЖУРАМД ЗААСАН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН ДЭЭШЛЭХЭЭР БАЙНА.**

### **ЗӨВЛӨМЖ:**

Дүгнэлтэд үндэслээд аймгийн ИТХ-ын даргад 4 заалт зөвлөмж, аймгийн Засаг даргад 2,912.1 сая төгрөгийн 6 заалт албан шаардлага, Орон нутгийн өмчийн газарт 1 заалт албан шаардлага, аймгийн ХБТХОХ-т 1 заалт зөвлөмж, сумдын ИТХ-д 44 заалт зөвлөмж, сумдын Засаг дарга нарт 92.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,724.2 сая төгрөгийн 78 заалт албан шаардлага тус тус хүргүүлжээ. Мөн өмнөх онуудын ТАХ-ээс гэрээний үүргийг хангалтгүй хэрэгжүүлсэн болон гэрээний үүргээ биелүүлээгүй талаас төрд учруулсан хохирлыг нэхэмжлүүлэхээр аймгийн Прокурорын газарт хандахаар шийдвэрлэсэн.

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

### **АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГАД: ЗӨВЛӨМЖ**

- 🔗 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн санал авсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж байх
- 🔗 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж байх
- 🔗 Хөгжлийн бодлогын урт дунд богино хугацааны баримт бичигтэй уялдаагүй хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхээр баталж байх
- 🔗 Төсөл, арга хэмжээний явц үр дүнд тогтмол хяналт тавьж, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлж ажиллах

### **АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД: АЛБАН ШААРДЛАГА**

- 🔗 Босго үнээс давсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж
- 🔗 Үнэлгээний хорооны гишүүнээр худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн иргэнийг томилох
- 🔗 Сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, иргэн, ААН-д ашиглуулж байгаа хөрөнгөд гэрээ байгуулж
- 🔗 Төлбөрийн баримтгүй гүйлгээг залруулан нөхөн шивүүлэх
- 🔗 Удирдлага мэдээллийн системийг бүрэн хөтөлж, түүнд тавих хяналтыг сайжруулан ажиллах
- 🔗 Гэрээний үүргээ биелүүлээгүй чанар, үр дүн хангалтгүй байгаа хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, ажлыг бүрэн гүйцэтгүүлж төсвийг хохиролгүй болгох

### **АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАРТ**

